



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд  
Монгол Ардын Хувьсгалт намаас нэр дэвшигчдийг  
бүртгэх тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.5, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.9, 31.10 дахь хэсэг, дүүргийн Сонгуулийн хорооны 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн дүүргийн Сонгуулийн хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Ардын Хувьсгалт намаас Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 3 дугаар тойрогт нэр дэвшүүлсэн Н.Уламбаяр /ОЮ81072715/, 9 дүгээр тойрогт нэр дэвшүүлсэн Ё.Бямбатогтох /ИЮ79072316/, 16 дугаар тойрогт нэр дэвшүүлсэн Т.Баасандулам /ЧИ83110466/, 23 дугаар тойрогт нэр дэвшүүлсэн Э.Магнайбаяр /Р384070951/ нарыг нэр дэвшигчээр бүртгэсүгэй.

2. Монгол Ардын Хувьсгалт намаас Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигчдийг бүртгэсэн тухай шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Нарийн бичгийн дарга Д.Дэлгэрмаад даалгасугай.

3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Монгол Ардын Хувьсгалт намаас нэр дэвшигчдэд нэр дэвшигчийн үнэмлэх олгосугай.

ДАРГА



Я.ЭРДЭНЭСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

Д.ДЭЛГЭРМАА

0000000027